



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 5 дугаар сарын 06-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 5 дугаар сарын 06-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Ж.Батсуурь, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн, Д.Энхтүвшин;

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Н.Наранбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 5 дугаар сарын 06-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг” танхим 15 цаг 22 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирц 53.3 хувь байна аа. Ирсэн гишүүдийг танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Ренчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Пүрэвжавын Ганзориг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвжавын Сайнзориг, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Цэрэнпилийн Даваасүрэн, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар нарын гишүүд ирсэн байна аа. Далайн Батбаяр гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.3 болсон. Батбаяр гишүүнийх ороод 56.7 хувьтай бүрдсэн тул 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё оо.

Нэг дэх асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт ээлжит хуралдаанаар чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын даргаас сар бүр захирамжаар батална. гэж мөн зүйлийн 5.6-д дахь хэсэгт энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ.” гэж заасны дагуу боловсруулсан Байнгын хорооны тогтоолыг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу?

Гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

30 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 55.6 хувиар дэмжигдлээ.

Батбаяр гишүүнийг дэмжсэнд протоколд тэмдэглээрэй.

Санал хураалт явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

15.26 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА